

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА АМЬТАН, УРГАМЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ИРГЭДИЙН ЗАН ТӨЛӨВ

*Д. Содномзул
Магистр*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Менежментийн сургууль*

zul@must.edu.mn

Хураангуй: Монгол улсад сүүлийн жилүүдэд экологийн тэнцвэрт байдал алдагдаж, биологийн төрөл зүйлийн хомсдол нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж гүнзгийрсээр байна. Тухайлбал, ховор болон нэн ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ нь биологийн төрөл зүйлийн хомсдолд шууд болон шууд бусаар нөлөөлөх болсон нь анхаарал татах асуудал юм. Энэ нь ихэнх иргэдийн байгаль орчны талаарх ойлголт, экологийн үнэ цэнийн талаарх мэдлэг хязгаарлагдмал, хариуцлагатай хэрэглээний талаарх ухамсар сул байгаатай холбоотой. Иймд энэхүү өгүүлэлд КАР загварт тулгуурлан Монгол улсын иргэдийн амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой зан төлөвийг судалж, хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогын суурь мэдээллийг боловсруулах зорилго тавьсан болно.

Түлхүүр үг: КАР загвар, зан төлөв, мэдлэг, хандлага, иргэдийн оролцоо

УДИРТГАЛ

XXI зуунд байгаль орчны тогтвортой байдлын алдагдал, биологийн олон төрөл зүйлийн хомсдол нь дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй ноцтой асуудлуудын нэг болоод байна. Биологийн төрөл зүйл нь экосистемийн тэнцвэрт байдал, хүний амьдралын чанар, байгалийн нөөцийн зохистой хэрэглээний үндэс суурийг бүрдүүлдэг [1]. Гэвч дэлхийн улс орнуудын хүн амын хэрэглээний хандлага, эдийн засгийн өсөлт, хууль бус худалдаа нь ховор болон нэн ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний эрэлт хэрэглээг нэмэгдүүлж, байгаль орчны тулгамдсан асуудал болон хувирч байна [2].

Монгол улсын хувьд уламжлалт хэрэглээний хэв маяг, хууль эрх зүйн хэрэгжилтийн сул байдал, зах зээлийн эрэлт зэрэг нь ховор амьтан, ургамлын хууль бус хэрэглээг дэмжих нөхцөлийг бүрдүүлж байна [3]. Үүний үр дүнд экологийн хариуцлагатай хэрэглээний тогтолцоо алдагдаж, байгаль орчны тогтвортой байдалд эрсдэл үүсч байна. Иймээс иргэдийн экологийн мэдлэг, хандлага, хэрэглээний зан төлөвт дүн шинжилгээ хийх нь нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, бодлого боловсруулалтад шинжлэх ухааны үндэслэлтэй суурь мэдээлэл бий болгох зайлшгүй шаардлагатай болж байна.

Судалгааны суурь онол нь хэрэглэгчийн зан төлөв нь зөвхөн бүтээгдэхүүний үнэ болон чанараас бус, тэдний байгаль орчны талаарх мэдлэг, үнэлэмж, хандлагаас ихээхэн хамаардаг [4]. Олон улсын судалгаануудын үр дүнгээс харахад олон нийтийн экосистемийн үнэ цэнийн талаарх ойлголт дутмаг байгаа нь хууль бус хэрэглээний гол шалтгаануудын нэг болж байна [5].

Судалгаанд ашигласан КАР (Knowledge-Attitude-Practice)

загвар нь тухайн иргэний байгаль орчны талаарх мэдлэг, хандлага болон хэрэглээний зан төлөвийн уялдаа холбоог тогтоох үр дүнтэй арга зүй юм [6].

Судалгааны зорилго нь Монгол улсын иргэдийн ховор болон нэн ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээний талаарх мэдлэг, хандлага, зан төлөвийг тодорхойлох бөгөөд зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв:

1. Монгол улсын иргэдийн экологийн мэдлэгийн түвшинг тодорхойлох
2. Ховор болон нэн ховор амьтан, ургамлын хэрэглээтэй холбоотой иргэдийн хандлагыг судлах
3. Байгаль орчны талаарх зан үйлийн төлөвийг судлах
4. КАР загварын хүрээнд мэдлэг, хандлага, туршлагын харилцан уялдааг шинжлэх.

Энэхүү судалгаагаар Монгол улсын иргэдийн экологийн мэдлэгийн

түвшин, ховор болон нэн ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой хандлага, байгаль орчинд ээлтэй эсвэл сөрөг зан төлөвийн онцлогийг КАР загварт тулгуурлан нарийвчлан судалсан. Мөн хууль бус хэрэглээний суурь шалтгааныг зан төлөвийн талаас судалж, мэдлэг, хандлагын нөлөөг тодорхойлсон нь байгаль орчны тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой бөгөөд шинэлэг юм.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Ховор ургамал, зэрлэг амьтдын хууль бус худалдаа болон тэдгээрийн хамгаалалттай холбоотой асуудал нь олон улсын хэмжээнд байгаль орчны бодлого, тогтвортой хөгжил, иргэдийн зан төлөвийн судалгааны төвд багтсаар ирсэн. Монгол улсад ч энэхүү асуудал нь улам хурцдаж, хууль бус хэрэглээ нэмэгдэхийн зэрэгцээ олон нийтэд хүрэх мэдлэг, хандлага, туршлагын судалгаа шаардагдах болсон билээ. Иймд энэхүү судалгаанд онолын үндэслэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн КАР загвар болох хэрэглээний зан төлөвийн онолд тулгуурлан боловсруулсан болно. КАР судалгааны загвар нь хувь хүний мэдлэг, хандлага, туршлагыг хэмжих бөгөөд эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн хөгжлийн олон салбарт өргөн хэрэглэгддэг арга зүйн загвар юм [6]. Энэхүү загварын гол онцлог нь тухайн

нийгмийн бүлгийн тодорхой сэдвийн талаарх мэдээлэл, ойлголт ямар байдалтай байгаа, хэрхэн ханддаг, амьдралын дадалд хэрхэн илэрч байгааг тодорхойлоход оршдог. Энэ нь нийгмийн хүлээлт, хувь хүний мэдлэг, хандлага, мөн тухайн хүний хуримтлуулсан зан үйлийг хянах туршлага зэргээс хамаарч төлөвлөгддөг гэж үздэг [7]. Судалгаанд ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээнд хандах иргэдийн байр суурь, нийгмийн хүлээлтийг хүлээн зөвшөөрөх хандлага, мөн хариуцлагатай хэрэглээг өөрийн сонголтоор хэрэгжүүлэх боломжтой гэсэн ухамсар, итгэл үнэмшлийг тодорхойлсон болно [8]. КАР загварын хандлага ба туршлагын хэсэг нь хүний зан төлөвийг зорилгод чиглэсэн, ухамсартай хэлбэрээр төлөвлөх боломжийг тайлбарладаг онолд үндэслэгддэг [8], харин экологийн боловсрол болон мэдлэг нь хувь хүний байгальд хариуцлагатай хандах ойлголт, хандлагын суурь үндэс болдог бөгөөд энэ нь КАР загварын мэдлэгийн хэсэгт багтана [9]. Судалгааны агуулгад холбогдох байгаль орчны боловсролын ойлголт нь хувь хүн байгаль орчинд ээлтэй зан төлөвийг эзэмшихийн тулд мэдлэг, ойлголт, үнэт зүйл, чадамж зэргийг агуулсан цогц чадварыг эзэмшсэн байх ёстойг тодорхойлдог [10]. Судалгаанд оролцогчдын байгаль орчны талаарх мэдлэг, мэдээлэл авах сувгийн

түвшин нь энэхүү загвартай шууд уялдаж байв.

Сүүлийн жилүүдэд хариуцлагатай хэрэглээний ойлголт нь хүний эрх, байгаль орчны хамгаалал, шударга худалдаа болон тогтвортой үйлдвэрлэлийн зарчимтай уялдан өргөжиж байна. Энэ нь хэрэглэгч худалдан авалтын шийдвэр гаргахдаа ёс зүйн, экологийн болон нийгмийн үр дагаврыг харгалзан үзэх шаардлагатайг илэрхийлдэг [2]. Гэвч судалгаанд оролцсон иргэдийн дунд хариуцлагатай хэрэглээний талаарх мэдлэг, ойлголт дутмаг байгаагийн зэрэгцээ зан төлөв нь тогтворжиж амжаагүй байгааг энэхүү онолын суурь хандлага тодорхой харуулж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааны мэдээллийг КАР загварт тулгуурлан Google Forms платформ ашиглан боловсруулсан цахим асуулга нь мэдлэг, хандлага, туршлагын уялдаа холбоог тодорхойлоход чиглэсэн. Асуулгын бүтэц нь хаалттай болон хагас нээлттэй асуултуудыг багтаасан бөгөөд судалгааны зорилгод нийцсэн олон талт мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүлсэн. Судалгааны арга зүйн хувьд чанарын болон тоон судалгааны аргуудыг хослуулсан холимог аргачлалын загварыг ашигласан бөгөөд энэ нь өгөгдөлд суурилсан бодит дүгнэлт гаргах боломжтой юм.

Зураг 1. КАР судалгааны загвар




Тоон судалгаагаар иргэдийн демографийн үзүүлэлтүүд, худалдан авалтын түүх, ховор ургамал, ан амьтдын талаарх мэдлэгийн түвшин, мөн тэдний хандлага, зан төлөвийн хэлбэрүүдийг хэмжсэн. Харин чанарын судалгаагаар иргэдийн субъектив ойлголт, үнэт зүйлс, нийгмийн хүлээлт, орчны нөлөөллийг гүнзгийрүүлэн судалсан нь хандлага болон практик зан төлөвт нөлөөлөх суурь хүчин зүйлсийг тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Судалгааны хүрээнд Улаанбаатар хот болон 18 аймагт амьдарч буй нийт 109 иргэнээс асуулга авах замаар мэдээлэл цуглуулж, үр дүнг боловсруулсан болно. Насны ангиллаар авч үзвэл судалгаанд оролцогчдын 32.1% нь 40-50 насны, 39.5% нь 25-34 насны, 14.7% нь 35-39 насны иргэд байжээ. 18 хүртэлх болон 50-аас дээш насны иргэд харьцангуй бага буюу тус бүр 2.8% болон 5.5%-ийг эзэлж байна. Хүйсийн хувьд, оролцогчдын 65.1% нь эмэгтэй, 34.9% нь эрэгтэй байна.

Боловсролын түвшингийн хувьд 79.8% нь дээд боловсролтой, 11.9% нь бага, бүрэн дунд боловсролтой, 8.3% нь техник, мэргэжлийн боловсрол эзэмшсэн байна. Энэхүү бүрдэл нь судалгаанд оролцсон иргэдийн нас, хүйс, боловсролын түвшний хувьд олон талт байдал, төлөөллийг хангаж байгаа юм.

Судалгаанд оролцсон иргэдийн 47.7 хувь нь бүтэн эсвэл хагас цагаар ажилладаг, 12.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, мөн 12.8 хувь нь боловсролын байгууллагад суралцдаг, 1.8 хувь нь гэрээт, улирлын чанартай эсвэл хэсэгчилсэн ажил эрхэлдэг хүмүүс байсан бол 3.7 хувь нь гэрийн ажилтай, 1.8 хувь нь эрхэлсэн ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүмүүс байна. Албан тушаалаар нь авч үзвэл 21.1 хувь нь удирдах албан тушаалтай, 54.1 хувь нь гүйцэтгэх ажилтан, мөн 21.1 хувь нь малчин, 23 хувь нь бусад албан тушаалтай иргэд байлаа. Иргэдийн орлогын түвшинг худалдан авах чадвараар илэрхийлэн тандахад: (зураг 2)

Зураг 2. Өрхийн санхүүгийн байдал, хувиар




Иргэдийн орлогын түвшин нь үндсэн хэрэглээ (хоол хүнс, хувцас) болон ахуйн хэрэглээ (техник, тавилга), хөрөнгө

оруулалтын чадвар (орон сууц, автомашин) дээр илт ялгарал үүсгэж байгааг энэхүү судалгаа харуулж байна. Ихэнх хүмүүсийн орлого үндсэн хэрэглээг л хангах түвшинд байгаа нь эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн бие даасан байдал сул байгааг илэрхийлж байна.

Судалгаанд оролцогчдын худалдан авалтын түүх болон төлөвлөгөөг тодруулахад сүүлийн 3 жилийн хугацаанд өөртөө эсвэл өөр хэн нэгэнд зориулан 66.7 хувь нь ухаалаг гар утас, таблет, цаг, 46.3 хувь нь модон тавилга хэрэгсэл, 42.6 хувь нь автомашин, тээврийн хэрэгсэл худалдан авсан гэжээ. Мөн 29.6 хувь нь компьютер, тоног төхөөрөмж, 35.2 хувь нь алт, үнэт эдлэл худалдан авсан бол 39.8 хувь нь амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг өөртөө эсвэл хэн нэгэнд зориулан худалдан авсан байна. Түүнчлэн иргэдийн 5.6 хувь нь ойрын хоёр жилийн хугацаанд амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг худалдан авахаар төлөвлөсөн бол нөгөө талаас иргэдийн 54.6 хувь нь энэ төрлийн бүтээгдэхүүнийг огт худалдан аваагүй бөгөөд цаашид ч худалдан авахгүй гэдгийг илэрхийлжээ. Харин амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн худалдан авсан болон худалдан авахаар төлөвлөсөн иргэдийн 93.9 хувь нь эмийн ургамал, мөн 69.4 хувь нь арьсан гутал, цүнх 14.3 хувь нь арьсан болон үст хувцас, эдлэл, хэрэгсэл, 12.2 хувь нь ангийн мах худалдан

авсан болоод худалдан авахаар төлөвлөсөн хэмээн хариулжээ. (зураг 3)


Зураг 3. Амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг худалдан авсан болон худалдан авахаар төлөвлөсөн байдал



Судалгаанаас үзэхэд байгаль, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн дотроос эмийн ургамал болон арьсан эдлэлүүд хамгийн өргөн хэрэглэгддэг байна. Харин зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ багасаж, нийгмийн ухамсар, хууль эрх зүйн хяналт нэмэгдсэн буй болзошгүй байна. Энэ нь байгаль хамгаалах хандлагын өөрчлөлтийг илэрхийлэх эерэг дохио байж болно.

Иргэд амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг ихэвчлэн их дэлгүүр, зах, худалдааны төвүүдээс мөн дуудлага эсвэл үзэсгэлэн худалдааны үеэр худалдан авдаг, харин захиалгаар, цахим худалдаа, хувь хүн, гадаад улсаас худалдан авах нь бага байна. (зураг 4)


Зураг 4. Амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг худалдан авсан газар



Эмийн ургамал (47%), зэрлэг амьтны үс бүхий хувцас 50%, арьсан болон үст хувцас, эдлэл


хэрэгсэл (35%), ангийн мах (25%), арьсан гутал, цүнх (30%) зэрэг бүтээгдэхүүний ихэнхийг хүмүүс их дэлгүүр, худалдааны төвөөс худалдан авсан нь харагдаж байна. Энэ нь албан ёсны худалдааны газрууд эдгээр бүтээгдэхүүний гол эх сурвалж болж буйг харуулж байна.

Зураг 5. Иргэдийн худалдан авах шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлс



Иргэд тухайн бүтээгдэхүүний чанар, үнэ, сертификат бүхий хууль ёсны бүтээгдэхүүн мөн эсэх, хууль бус ангийн бүтээгдэхүүн эсэхийг нягталсны эцэст амьтны гаралтай арьс, үсэн бүтээгдэхүүнийг худалдан авах шийдвэр гаргаж байна. Худалдан авах бүтээгдэхүүн нь ангийн арьс, зэрлэг амьтны үс орсон байх эсэх нь тийм ч чухал биш гэж үзжээ.

Зураг 6. Иргэдийн амьдралын хэв маяг



Иргэдийн 45.9 хувь нь ургамал тарьдаг, 26.6 хувь нь амьтан тэжээдэг, 3.7 хувь нь ангийн махаар хоол хийх тохиолдол байдаг, 1.8 хувь нь ан амьтан үржүүлж, тэжээдэг гэсэн бол 38.5 хувь нь ан,

амьтны салбарт хамааралгүй иргэд, харин 3.7 хувь нь экологи, ан амьтны салбарт ажиллаж амьжиргаагаа залгуулдаг иргэд байна.


Судалгаанд хамрагдсан иргэдээс нутагт нь байдаг ан амьтны төрлийг асуухад 79.8 хувь нь монгол тарвага, 29.4 хувь нь талын бүргэд, 27.5 хувь нь эдлэг шонхор, 11 хувь нь ирвэс, 7.3 хувь нь бадгана хүдэр байдаг гэж хариулжээ.

Зураг 7. Орон нутагт нь байдаг ан амьтны төрөл, иргэдийн харилт, хувиар



Иргэд өөрсдийн орон нутагт байдаг ан амьтны нэр төрлийг мэдэж байгаа боловч амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний талаар 76.4 хувь нь мэдэхгүй, сонсож байгаагүй гэж хариулсан байна.


Зураг 8. Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний талаарх мэдлэг, хувиар



Оршин суугаа аймагт орон нутагт нь зэрлэг ан, амьтны төрөл зүйл худалдах, худалдан авах тохиолдолд 2-3 жилийн өмнөхтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаарх иргэдийн ойлголтыг нь

тодруулсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн 18 хувь нь сүүлийн жилүүдэд буурсан, 11 хувь нь өөрчлөгдөөгүй, 3 хувь нь нэмэгдсэн гэж хариулсан бол 68 хувь нь энэ талаар мэдэхгүй гэжээ. Аймгуудаар авч үзвэл Өмнөговь, Баян-Өлгий аймгаас судалгаанд оролцсон иргэд 100 хувь, Увс, Говь-Алтай аймгаас судалгаанд оролцсон иргэдийн 50 хувь, Ховд аймгаас судалгаанд оролцсон иргэдийн 40 хувь, Төв аймгаас судалгаанд оролцсон иргэдийн 5 хувь нь 2-3 жилийн өмнөх нөхцөл байдалтай харьцуулахад зэрлэг ан, амьтны төрөл зүйлийг худалдах тохиолдолд багассан гэж үзэж байна. Судалгаан хамрагдсан Сүхбаатар аймгийн иргэд 100 хувь, Сэлэнгэ аймгийн иргэдийн 33 хувь, Ховд аймгийн иргэдийн 20 хувь, Төв аймгийн иргэдийн 18 хувь нь өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ төрлийн үйлдэл өөрчлөгдөөгүй гэж дүгнэн хариулжээ. Харин судалгаанд хамрагдсан Ховд аймгийн иргэдийн 20 хувь, Өвөрхангай аймгийн иргэдийн 8 хувь, нийслэлийн иргэдийн 2 хувь өмнөх жилүүдээс зэрлэг ан, амьтны худалдаа нэмэгдсэн гэж үзжээ. (зураг 9)

Зураг 9. Зэрлэг ан, амьтны төрөл зүйл худалдах, худалдан авах тохиолдолд 2-3 жилийн өмнөхтэй харьцуулахад өөрчлөгдсөн эсэх, иргэдийн ойлголт хувиар



Амьтны тухай хуульд нэн ховор амьтныг жагсаасан байдаг [11], харин ховор амьтныг ЗГ-ын жагсаалтаар баталдаг [12]. Эдгээр нэн ховор болон ховор амьтад МУ-ын Улаан ном болон олон улсад давхар хамгаалагдсан байдаг [13, 14]. Иргэдээс ирээдүйд та болон танай гэр бүлийн хэн нэгэн улаан номд орсон, нэн ховор ургамал, ан амьтныг агнах, худалдах, худалдан авах хандлагыг тодруулахад судалгаанд хамрагдсан иргэдийн 86 хувь нь мэдээж үгүй, боломжгүй гэсэн бол 11 хувь нь магадгүй, 3 хувь нь тийм гэж хариулсан байна. (хүснэгт 1)

Хүснэгт 1. Нэн ховор ургамал, ан амьтныг агнах, худалдах, худалдан авах хандлага, хувиар

Эргэлтэй бус, боловсролын түвшин, эрх, эрхэм зүйлсийг	Мэдээ үгүй	Боломжгүй	Идэвхгүй	Төлөөл, шаардлага	Хэвд	
Нэн	40-аас дээш	38.0	59.1	16.7	-	100.0
	30-40	37.9	23.7	15.8	2.8	100.0
	20-30	41.9	26.6	2.9	8.3	100.0
	20-аас доош	43.3	14.7	-	-	100.0
Боловсрол	Багш, дунд, дунд, дунд	36.5	38.8	23.1	7.7	100.0
	Төрийн, мэргэжлийн	39.6	59.3	11.1	-	100.0
	Дунд	35.2	33.3	9.2	2.3	100.0
Хэрэглэ	Энэ	52.1	39.8	11.3	2.8	100.0
	Эр	55.3	32.6	14.1	2.9	100.0
Өрхийн эрхэм	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	41.8	37.1	23.0	-	100.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	46.0	32.0	18.0	12.0	100.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	46.9	34.8	6.1	-	100.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	42.5	27.2	-	-	100.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	44.8	27.0	14.3	-	100.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	46.0	18.0	-	-	100.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	39.2	23.0	11.0	2.8	100.0
	Ийнхүү					

Судалгаанаас үзэхэд 50-иас дээш насны хүмүүс 100 хувь ирээдүйд нэн ховор ургамал, ан амьтныг агнах, худалдах, худалдан авахгүй, боломжгүй гэж хариулсан нь хууль зөрчих үйлдлийг эрс эсэргүүцдэг болохыг илтгэнэ. Харин залуу үеийн дунд энэхүү асуудлын талаарх ойлголт, үнэлэмж бүрэн төлөвшөөгүй байж болзошгүйг илэрхийлж байна. Энд боловсролын түвшин нэмэгдэх тусам тухайн асуудлын талаарх ойлголт нэмэгддэг болохыг судалгааны үр дүн харуулж байна. Түүнчлэн орлогын ангиллаар нь авч үзвэл өрхийн орлого нь шаардлагатай гэр ахуйн тавилга, цахилгаан хэрэгсэл худалдан авахад хүрэлцэхүйц, мөн хангалттай хэмжээний өндөр орлоготой иргэд бүгд ийм үйлдэл ирээдүйд хийхгүй, боломжгүй гэж хариулсан байна. Харин бага орлоготой иргэдийн 25 хувь нь ирээдүйд ийм үйлдэл хийж магадгүй гэж хариулсан бол бусад нь хийхгүй гэдгээ илэрхийлжээ.

Мөн өрхийн орлого нь хүнсэндээ хүрэлцдэг боловч шинэ хувцас худалдан авахад хараахан хүрэлцдэггүй иргэдийн 12 хувь нь тийм, 16 хувь нь ирээдүйд энэ үйлдлийг хийж магадгүй гэж хариулжээ. Эндээс харахад иргэдийн ирээдүйд улаан номд орсон, нэн ховор ургамал, ан амьтныг агнах, худалдах, худалдан авах хандлага нь өрхийн орлогоос хамааран ялгаатай байна. Орлого багатай иргэд болон тэдний гэр бүлийн гишүүд ирээдүйд тухайн үйлдлийг хийх магадлалтай болж байна. Энэ нь амьжиргааны түвшин өндөр байх тусам байгаль хамгааллын талаарх мэдээлэл, мэдлэг, хариуцлагатай хандлага нэмэгддэг гэсэн үзэл баримтлалыг баталж байна.

Иргэдээс зарим хүн, хуулийн этгээд нь яагаад нэн ховор болон ховор амьтдыг агнаж, худалдаа хийдэг шалтгааныг юу гэж үзэж байгааг тодруулахад: (хүснэгт 2)


Хүснэгт 2. Хууль бус ан, худалдааг үйлдэх шалтгааны талаарх иргэдийн бодол, хувиар

Эргэлтэй бус, боловсролын түвшин, эрх, эрхэм зүйлсийг	Мэдээ үгүй	Боломжгүй	Идэвхгүй	Төлөөл, шаардлага	Хэвд	
Нэн	40-аас дээш	-	8.3	18.0	14.7	100.0
	30-40	-	2.6	7.8	15.8	73.7
	20-30	6.6	6.7	6.7	28.0	60.0
	20-аас доош	-	-	-	18.0	18.0
Боловсрол	Багш, дунд, дунд, дунд	-	15.4	13.4	15.4	53.6
	Төрийн, мэргэжлийн	11.1	-	-	23.7	34.8
	Дунд	2.9	2.9	6.9	25.3	41.2
Өрхийн эрхэм	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	-	12.0	12.0	12.0	36.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	-	4.0	16.0	16.0	40.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	6.3	6.7	-	21.7	34.7
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	-	-	6.3	23.0	29.3
	Мөнгө хөр, үйлд хөрөнгөтэй, гэдэг байсан, өрөөлүүтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	7.4	-	7.4	22.2	37.0
	Мөнгө хөрөнгөтэй бус (мөнгө хөрөнгөтэй)	-	-	-	28.0	28.0
	Ийнхүү	2.8	6.7	7.1	24.8	41.5

судалгаанд хамрагдсан иргэдийн 61.5 хувь нь хууль бус ан, худалдаа үйлдэх ямар ч шалтгаан байхгүй гэж үзсэн нь олонхын хувьд хууль зөрчих үйлдлийг хүлээн зөвшөөрдөггүй, хариуцлагатай хандлагатай байгааг харуулж байна. Харин 32.1 хувь нь тухайн иргэн эсвэл өрхийн амьжиргааны эх үүсвэргүй, өдөр тутмын үндсэн хэрэгцээгээ хангахын тулд, 6.5 хувь нь эрүүл мэндийн зардлыг төлөх эсвэл гэрийн засварын зардлыг олохын тулд хууль бусаар ургамал, ан, амьтны худалдаа эрхэлж болно гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, орлого багатай болон боловсролын түвшин доогуур бүлгийн дунд амьжиргааны хүндрэлтэй үед ийм үйлдлийг ойлгож болох шалтгаан хэмээн үзэх хандлага илүү ажиглагдаж байна.


Судалгаанд хамрагдсан иргэдийн 56.4 хувь нь зэрлэг ан амьтдыг агнах, хууль бусаар худалдаалах нь байгаль орчин, эдийн засаг, нийгэмд сөрөг нөлөөтэй гэж үзсэн бол 10.9 хувь нь байгаль орчин эдийн засагт, 24.5 хувь нь зөвхөн байгаль орчинд сөрөг нөлөөтэй, 8.2 хувь нь итгэлгүй бөгөөд өөр бусад хүчин зүйлд сөргөөр нөлөөлнө гэж хариулсан.

Зураг 10. Зэрлэг ан амьтны хууль бус ан, худалдааны сөрөг нөлөө, хувиар



Иргэдэд санал болгосон жагсаалтаас байгаль орчны эсрэг гэмт хэргийн хүнд хэлбэрт хамаарах гурав хүртэл хариултыг сонгуулж энэ талаарх мэдлэг ямар байгааг тандлаа. (зураг 11)

Зураг 11. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн хүнд хэлбэрт аль нь хамаарах талаарх иргэдийн бодол, хувиар



Судалгаанд хамрагдсан иргэдийн 73.4 хувь нь нэн ховор болон ховор амьтны төрөл, зүйлийг агнах, худалдаалах, 48.6 хувь нь устаж буй ховор ургамлыг тастах, цуглуулах, зарах, 36.7 хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт ан хийх болон газрыг хууль бусаар өөрчлөх, 31.2 хувь нь зэрлэг ан амьтныг агнах, худалдаалах нь байгаль орчны эсрэг хүнд хэлбэрийн гэмт хэрэг юм гэж үзэж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол улсын иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг, хандлага, зан төлөв нь тэдний нас, боловсролын түвшин, өрхийн орлого зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсээс хамааран харилцан адилгүй байна. Нас ахих тусам хууль бус ан, худалдааг эсэргүүцэх хандлага нэмэгдэж байгаа бол, бага орлоготой бүлгийн дунд амьжиргааны хүндрэлийн улмаас хууль бус хэрэглээг ойлгож болох

нөхцөл гэж үзэх хандлага ажиглагдаж байна. Иргэдийн ихэнх нь нэн ховор амьтдыг агнах, худалдах үйлдлийг хүлээн зөвшөөрдөггүй, хууль зөрчих ёсгүй гэж үздэг нь нийгэмд экологийн хариуцлагатай хандлагыг төлөвшүүлэхэд боломж байгааг харуулж байна. Түүнчлэн албан ёсны худалдааны төвүүд байгаль, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний гол эх сурвалж болж байгааг тодорхойлсон нь хууль ёсны худалдааг дэмжих бодлогын ач холбогдлыг илэрхийлж байна.







Судалгаанд хамрагдсан иргэдийн 66.7 хувь нь амьдралын шаардлагаар аргагүйн эрхэнд гэсэн шалтгаанаар ховордсон ургамал, ан амьтны төрөл зүйлийг худалдаж авах, худалдах үйлдэл хийх нь байж болшгүй гэж үзсэн байна. Гэвч иргэдийн 18.5 хувь нь энэ нь байж болох асуудал хэмээн үзэж санал нийлнэ гэж хариулжээ. Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 56.5 хувь нь ихэнх хүмүүс зэрлэг ан амьтан, ургамлын хууль бус худалдаанд оролцдоггүй гэдэгтэй бүрэн санал нийлсэн бол 30.6 хувь нь санал нийлэхгүй байгаа нь зарим иргэд ургамал, ан амьтдын хууль бус худалдааны үйл ажиллагаанд оролцдог байж болохыг харуулж байна. (хүснэгт 3)

Нэн ховор, ховор амьтан, ургамлын худалдааг хорьж цагдах шаардлагагүй, ер нь элбэг байгаа гэсэн асуултад 71.3 хувь нь огт санал нийлэхгүй гэснээс харахад

иргэдийн дийлэнх нь нэн ховор болон ховор ургамал, амьтдын худалдааг хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна. Хууль бусаар ургамал түүх ан агнах, худалдах нь их нарийн, цөөн тооны хөрөнгөлөг, эрх мэдэлтэй хүмүүсийн бизнес болсон гэсэн асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 24.1 хувь нь энэ талаар мэдэхгүй, 28.7 хувь нь ийм асуудал байхгүй, санал нийлэхгүй байна гэж хариулсан бол 47.2 хувь нь хөрөнгө, эрх мэдэлтэй хүмүүсийн бизнес болсон гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 45.4 хувь нь ан амьтан, ургамлыг элбэг олон байхад нь агнах түүж ашиглах нь чухал болохоос устаж үгүй болох гэж байхад нь шунаад хэрэггүй гэж үзсэн бол 36.1 хувь нь ямар ч тохиолдолд ан амьтдыг агнах, ургамлыг түүж тасдах нь байж болшгүй гэж үзсэн байна. Нөгөө талаас иргэдийн 47.2 хувь нь байгаль дээр ховордоод байгаа ч амьтан ургамлыг тарималжуулах, аж ахуй байгуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах хэрэгтэй гэж үзсэн бол 33.3 хувь нь эсрэг байр суурьтай байна. Эдгээр асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 16.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байгаа нь тэдний мэдлэг, мэдээлэл ховор байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Иргэдийн хандлага

Асуулт	Ог сонголттой байдал	Санаа шалтгаангүй байдал	Санаа шалтгаантай байдал	Мөн их сонголттой байдал	Мэдэггүй	График
Ховорсон ургамал, ан амьтны төрөл зүйлийг худалдаж авах, худалдах нь ирээдүйн амьдралын шаардлагаар иргэдгүй эрхэнд хийгддэг.	39.8	26.9	15.7	2.8	14.8	
Ихэнх хүмүүс эрлэг ан амьтан, ургамалыг хууль бус худалдаанд оролцохгүй байгаа.	8.3	22.2	46.3	10.2	13.0	
Нэн ховор, ховор амьтан, ургамалыг худалдааг хорьж яахад шаардлагагүй, ер нь зөв байгаа.	39.8	31.5	11.1	6.5	11.1	
Хууль бусар ургамал түүх ан агнах, худалдах нь их илрлийн, дөөн томоо оролцогч, эрх мэдэлтэй хүмүүсийн бизнес болсон.	11.1	17.6	28.7	18.5	24.1	
Ан амьтан, ургамалыг зөвгөсөн байхад нь агнах түүж ашиглах нь эрхэл болохоос уусаж үгүй болж гэж байхад нь шуудад хэрэггүй.	13.0	23.1	32.4	13.0	18.5	
Байгаль дээр ховорлоход байгаа ч амьтан ургамалыг тариамаагуулах, аж ахуй байгуулах замаар хэний эрхэлдэг эрхэлдэг оролцсон нь дээр.	13.9	19.4	30.6	16.7	19.4	

Дээрх судалгаагаар иргэдийн олонх нь нэн ховор амьтан, ургамлын хууль бус худалдааг үл зөвшөөрч, хамгааллын бодлогыг дэмжиж байгаа ч тодорхой хэсэг нь ашиг орлого, мэдлэг дутмаг байдлаас үүдэн зөрүүтэй хандлагатай байгааг харуулж байна.


ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол улсад нэн ховор болон ховор амьтан, ургамлын хууль бус хэрэглээ, түүнийг дагасан худалдаа нь байгаль орчны тогтвортой байдлын алдагдал, биологийн төрөл зүйлийн хомсдолын гол шалтгаануудын нэг болоод байна. Энэхүү судалгаагаар иргэдийн нэн ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой мэдлэг, хандлага, туршлага нь тэдний нас, боловсрол, өрхийн орлого,

хөдөлмөр эрхлэлт зэргээс тодорхой хамааралтай байна. Энэ нь олон улсын судалгааны чиг хандлагуудтай нийцэж байгаа бөгөөд хэрэглэгчийн зан төлөв нь зөвхөн бүтээгдэхүүний хэрэгцээ, үнэ ханшаас гадна хувь хүний ойлголт, үнэт зүйл, хандлага, мэдээлэлтэй шууд уялдаатай байдаг [4, 5]. Тухайлбал, UNEP тайланд дурдсанаар биологийн төрөл зүйлийн хомсдолын 60 орчим хувь нь хууль бус хэрэглээ, худалдаатай холбоотой байдаг бөгөөд энэ нь хэрэглэгчийн зан төлөвийг өөрчлөх шаардлагыг илэрхийлдэг [2].

Судалгааны таамаглалд үндэслэн хэрэглэгчийн мэдлэг, хандлага, туршлага (КАР) нь ховор амьтан, ургамлын хэрэглээнд нөлөөлдөг гэсэн таамгийг батлах үр дүн гарсан. Тухайлбал, КАР загварын бүрдэл хэсгүүд болох мэдлэг, хандлага, туршлагын хоорондын хамаарлыг Pearson-ийн корреляцийн коэффициентоор тооцоход харилцан эерэг хамааралтай байгааг тогтоосон. Зураг 12-д харуулснаар мэдлэгийн түвшин нэмэгдэхийн хэрээр хандлага, зан төлөв эерэг чиглэлтэйгээр өөрчлөгдөж буй нь КАР загварын онолын үндэслэлтэй бүрэн нийцэж байна.

Зураг 12. Мэдлэг, хандлага, туршлагын хоорондын корреляцийн харьцуулалт



1. Мэдлэг ба хандлага хоорондын хамаарал 0.80 буюу хүчтэй эерэг хамааралтай гарсан нь мэдлэг өндөр байх тусам хандлага илүү эерэг болох хандлагыг илтгэнэ.
2. Хандлага ба туршлага хоорондын хамаарал хамгийн өндөр буюу 0.95 байгаа нь хандлага нь зан төлөвт хамгийн хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл болохыг харуулж байна.
3. Мэдлэг ба туршлага хоорондын хамаарал 0.63 буюу харьцангуй сул гарсан нь мэдлэг нь зан төлөвт шууд бус замаар, хандлагаар дамжин нөлөөлдөг болохыг илэрхийлж байна.

Энэхүү үр дүнгийн хүрээнд хандлага нь мэдлэг ба туршлагын хоорондын зуучлагч (mediator) үүргийг гүйцэтгэж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, мэдлэгийг хандлагаар дамжуулан зан төлөвт шилжүүлэх үйл явц илүү үр дүнтэй байж болохыг нотолж байна. Иймээс зан төлөвт эерэг өөрчлөлт хийхэд мэдээлэл өгөхөөс гадна хандлагад чиглэсэн боловсрол, ухуулга, олон нийтийн мэдээллийн стратегиуд онцгой ач холбогдолтой юм.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь мэдлэг, үнэт зүйл дээр суурилсан хариуцлагатай хандлагатай байсан ч эдийн засгийн хүндрэл, мэдээллийн хүртээмжийн дутагдалтай зарим бүлгийн дунд зөрүүтэй байр суурь ажиглагдсан. Энэ нь Лаунила судлаачийн дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд тэрээр КАР загвар нь хэрэглэгчийн зан төлөвийг бүрэлдүүлж, хандлагад нөлөөлөх гол хүчин зүйлсийг ялган таних үр дүнтэй арга зүй болохыг онцолдог [6].

Мөн Ажзенийн төлөвлөсөн зан төлөвийн онолд дурдсанаар хувь хүний мэдлэг нь түүний шийдвэр гаргалтад шууд нөлөөлдөг хэмээн үздэг. Энэхүү судалгааны үр дүн нь уг онолтой нийцэж байгаа бөгөөд иргэдийн ихэнх нь хууль эрх зүйн мэдлэг болон нийгмийн хүлээлтэд үндэслэн байгаль хамгаалах хандлага төлөвшсөн нь нотлогдож байна.

Насны хувьд ахмад настай хүмүүсийн дунд ховор амьтныг агнах, худалдах үйлдлийг эрс эсэргүүцдэг хандлага давамгайлж байгаа бол, залуу үеийн дунд тодорхой бус, эргэлзээтэй хариултууд ажиглагдаж байгаа нь байгаль хамгаалах боловсролыг залууст чиглүүлэх шаардлагатайг харуулж байна. Боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр экологийн мэдлэг болон хариуцлагатай хэрэглээний талаарх ойлголт илүү төлөвшсөн байдлаар илэрч байгаа нь байгаль орчны

боловсролын онолын [10] үндэслэлийг баталгаажуулж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх нь (61.5%) хууль бус ан, худалдааг ямар ч нөхцөлд зөвтгөх боломжгүй гэж үзэж байгааг судалгааны онцлох үр дүнгийн нэг гэж үзэж болно. Гэвч орлого багатай иргэдийн дунд амьжиргааны шалтгаанаар ийм үйлдлийг ойлгож болох хандлага байгааг анхаарч үзэх нь зүйтэй. Энэ нь КАР загварын хүрээнд мэдлэг, хандлага, туршлагын хоорондын уялдаа хангалтгүй байгааг илэрхийлэхийн сацуу цаашид хэрэглэгчийн зан төлөвт ВСС (Behaviour Change Communication) хандлага шаардлагатайг харуулж байна [7].

Мөн иргэд бүтээгдэхүүн худалдан авахдаа голчлон үнэ, чанар, хууль ёсны гарал үүсэл, сертификатыг харгалзан үздэг ч бүтээгдэхүүнд ангийн үс, арьс орсон эсэх нь тийм ч чухал биш гэж хариулсан нь байгаль хамгааллын талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна. Үүнийг хэрэглэгчийн мэдлэг дутмаг байснаас болж хариуцлагагүй хэрэглээ рүү хөтлөгдөх эрсдэлтэй байдлыг [9] Шульцийн мэдлэг дутагдлын загвартай холбон тайлбарлаж болно.

WWF Mongolia [3] судалгаагаар мөн ижил дүгнэлт гарсан ба нийгмийн дэмжлэг, боловсролын түвшин, хууль сахих орчны сул байдал нь хууль бус хэрэглээ нэмэгдэхэд нөлөөлж буйг

тодорхойлсон. Энэ нь бидний судалгаанд "мэдэхгүй" гэж хариулсан 16.8 хувийн иргэдийн бүлэг байгаагийн шалтгааныг тайлбарлаж байна. Иймд хэрэглэгчийн зан төлөвийг өөрчлөхөд чиглэсэн боловсрол, мэдээллийн стратеги, олон нийтийн кампанит ажил зэрэг нь чухал ач холбогдолтой болохыг нотолж байна.

Эцэст нь, албан ёсны худалдааны төвүүд эмийн ургамал, ангийн мах, арьсан эдлэлийн гол эх сурвалж болж байгаагийн зэрэгцээ зэрлэг амьтны гаралтай хууль бус бүтээгдэхүүн эдгээр сувгаар нэвтэрч байж болзошгүй нөхцөлийг судалгааны үр дүн сануулж байна. Иймээс төр, хувийн хэвшлийн түвшинд хяналт шалгалт, хэрэглэгчийн боловсрол, олон нийтэд чиглэсэн кампанит ажил зэргийг цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Экологийн тэнцвэрт байдал алдагдаж, биологийн төрөл зүйлийн хомсдолын эсрэг тэмцэхэд иргэдийн зан төлөвийг ойлгож тодорхойлох нь бодлого боловсруулахад суурь ач холбогдолтой юм. Энэхүү өгүүлэл нь КАР загварын хүрээнд Монгол улсын иргэдийн ховор, нэн ховор амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой мэдлэг, хандлага, туршлагын уялдаа холбоог судалсан билээ.

1. Судалгааны үр дүнд Монгол улсын иргэдийн нэн ховор ургамал, амьтны хууль бус хэрэглээ, түүнийг дагасан худалдааг ихэнх нь ёс зүйгүй, хууль зөрчсөн үйлдэл гэж хүлээн зөвшөөрөөгүй нь байгаль хамгаалах хандлагын төлөвшил нэмэгдэж буйг илтгэж байв.
2. Иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг, хандлага, туршлага нь тэдний нас, боловсрол, өрхийн орлого, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлстэй уялдаж байгааг тогтоосон.
3. Нас ахих тусам болон боловсролын түвшин өндөр байх тусам хууль бус хэрэглээг эрс эсэргүүцэх хандлага давамгайлсан бол бага орлоготой иргэдийн дунд амьжиргааны шалтгаанаар хууль бус хэрэглээг ойлгож болзошгүй гэсэн үзэл оршин байв.
4. Эмийн ургамал, арьсан эдлэл зэрэг байгаль, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнүүд нь хэрэглээний хувьд зонхилж байсан бөгөөд тэдгээрийг иргэд албан ёсны худалдааны төвөөс худалдан авсан нь хууль ёсны худалдааны гол эх үүсвэр болж байсныг харуулсан.
5. Иргэд худалдан авалтын шийдвэр гаргахдаа үнэ, чанар, гарал үүсэл, сертификат зэргийг анхаардаг ч бүтээгдэхүүнд зэрлэг амьтны арьс, үс орсон эсэх нь төдийлөн чухал хүчин зүйл болж чадаагүй нь байгаль хамгааллын талаарх ойлголт дутмаг байгааг илтгэсэн.
6. Байгаль хамгааллын эсрэг гэмт хэргийн талаарх ойлголт дутмаг байсан бөгөөд “мэдэхгүй” гэсэн хариулт олонтаа илэрсэн нь олон нийтийн мэдээлэл, боловсролын хүртээмж хангалтгүй байгааг харуулсан.
7. Хууль бус хэрэглээг зарим иргэд хөрөнгө, эрх мэдэлтэй цөөн иргэдийн ашиг сонирхлын хэрэгсэл гэж ойлгож байсан нь төрийн хяналт, хариуцлагын механизмд итгэх итгэлд нөлөөлж байгааг илэрхийлсэн.
8. Судалгаагаар КАР загвар нь хэрэглэгчийн зан төлөв, мэдлэг, хандлага, туршлагын уялдаа холбоог тайлбарлахад үр дүнтэй арга зүй болохыг баталсан бөгөөд хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэхэд олон нийтийн боловсрол, зан төлөвийн өөрчлөлтөд чиглэсэн стратеги шаардлагатайг дүгнэсэн.

НОМ ЗҮЙ

1. *Millennium Ecosystem Assessment. Ecosystems and human well-being: Synthesis. Josi Sarukhōn and Anne Whyte (co-chairs) and MA Board of Review Editors // A Report of the Millennium Ecosystem Assessment «Island Press», 2005, PP. 1-6, DOI/ <https://www.millenniumassessment.org/documents/document.356.aspx.pdf>*
2. *UNEP (United Nations Environment Programme). Global Biodiversity Outlook 5. // Secretariat of the Convention on Biological Diversity, 2020, PP. 12-23, ISBN-9789292256883, <https://www.cbd.int/gbo5>*

3. WWF Mongolia. *Illegal Wildlife Trade in Mongolia: Assessment and Policy Recommendations*, 2021, <https://www.wwf.mn>, <https://www.worldwildlife.org/publications>
4. Ajzen, I. The theory of planned behavior, *Organizational Behavior and Human Decision Processes*, 50(2), 1991, PP. 179–211, [https://doi.org/10.1016/0749-5978\(91\)90020-T](https://doi.org/10.1016/0749-5978(91)90020-T)
5. Hungerford, H. R., & Volk, T. L. Changing learner behavior through environmental education. *The Journal of Environmental Education*, 1990, 21(3), PP. 8–21, <https://doi.org/10.1080/00958964.1990.10753743>
6. Launiala, A. How much can a KAP survey tell us about people's knowledge, attitudes and practices? *Anthropology Matters Journal* 11(1), 2009, PP. 1–13
7. WHO (World Health Organization). *Advocacy, communication and social mobilization for TB control: A guide to developing knowledge, attitude and practice surveys*, 2008
8. McBeth, W., & Volk, T. L. The National Environmental Literacy Project: A baseline study of middle grade students in the United States. *The Journal of Environmental Education* 41(1), 2010, PP. 55–67, <https://doi.org/10.1080/00958960903210031>
9. Schultz, P. W. *New Tools for Environmental Protection*, Chapter 4: Knowledge, Information, and Household Recycling: Examining the knowledge-deficit model of behavior change. In T. Dietz & P. C. Stern (Eds.), *New tools for environmental protection: Education, information, and voluntary measures*, «Washington, DC: National Academies Press», 2002, PP. 67–82, <https://nap.nationalacademies.org/>
10. McBride, B. B., Brewer, C. A., Berkowitz, A. R., & Borrie, W.T. Environmental literacy, ecological literacy, ecoliteracy: What do we mean and how did we get here? *Ecosphere* 4(5), 2013, PP. 1–20.
11. Монгол Улсын Амьтны тухай хууль. «Монгол Улсын Их Хурлын Хэвлэл», 2012 оны 5 дугаар сарын 17, <https://legalinfo.mn/mn/detail/14902>.
12. Ховор амьтны жагсаалт батлах тухай тогтоол (№7). «Монгол Улсын Засгийн газар», 2012 оны 7-р тогтоол», <https://legalinfo.mn/mn/detail/90967>
13. *Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora*. «CITES Convention Text», 1973, <https://cites.org/eng/disc/text.php>
14. International Union for Conservation of Nature. *The IUCN Red List of Threatened Species*, 2024, <https://www.iucnredlist.org>